# ЭХ, ХҮҮХДИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭ 2019-2023

**Л.ГАНБАТ**
ЭМНЭЛГИЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН ДАРГА
КЛИНИКИЙН ПРОФЕССОР,ТЭРГҮҮЛЭХ ЗЭРГИЙН ЭМЧ

**2024.04.25**

1. Эх, хүүхдийн эрүүл мэндийн үзүүлэлт

2. Хүүхдийн эндэгдлийн мэдээлэл

3. Дүгнэлт

3. Цаашид хэрэгжүүлэх арга хэмжээ

4. 2024 онд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн арга хэмжээ

# 1. ЭХ,ХҮҮХДИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮЗҮҮЛЭЛТ 2019-2023

2023 оны жилийн эцсээр аймгийн хэмжээнд нийт 689 эх төрсөн бөгөөд өмнөх оноос 13 төрөлтөөр өссөн.Нийт төрсөн эхчүүдийн 94,9 хувь буюу 654 эх нэгдсэн эмнэлэгт төрсөн байна. Анхан шатны ЭМТ –үүдэд 35 эх төрж 5,1 хувийг эзэлж байна.

Мөн 2023 онд аймгийн хэмжээнд 692 хүүхэд мэндэлсэн бөгөөд өнгөрсөн оноос 2,4 хувиар өссөн үзүүлэлттэй байна.Нийт төрсөн 692 хүүхдээс 49,7 хувь нь эрэгтэй,50,3 хувь нь эмэгтэй хүүхэд эзэлж байна.










Амьд төрсөн нийт хүүхдэд 2500 граммаас бага жинтэй хүүхэд 19 буюу 2,7 хувийг эзэлж байна.Төрөөд 1 цагийн дотор амлуулсан хүүхдийн хувь 98,6 байна.

# АМЬГҮЙ ТӨРӨЛТ
## /1000 амьд төрөлтөд/ 2019-2023 он

2023 онд амьгүй төрөлтийн тохиолдол бүртгэгдээгүй бөгөөд 2021,2022 онуудад ковидын халдварын шалтгаант амьгүй төрөлтийн тохиолдол олон байсан



# ӨСВӨР НАСНЫ 1000 ОХИДОД НОГДОХ ТӨРӨЛТИЙН ТҮВШИН 2019-2023









# ЖИРЭМСНИЙ ХЯНАЛТ
## 2019-2023 он







2023 онд 634 жирэмсэн эмэгтэй шинээр хяналтанд хамрагдсанаас жирэмсний эрт үеийн хяналт 91,3% болж өмнөх оноос 2,3 хувиар буурсан байна.

Нийт хяналтанд орсон эхчүүдийн 8,2 хувь нь хожуу хугацаанд хяналтанд орсон байна. Жирэмсний хожуу хяналтанд орсон эхчүүдэд өөр газраас шилжин ирсэн иргэд оюутнууд ,охид, малчин эмэгтэйчүүд ихэнх хувийг эзэлж байна.






## 2. ТАВ ХҮРТЭЛХ НАСНЫ ХҮҮХДИЙН ЭНДЭГДЭЛ /1000 амьд төрөлтөд / 2019-2023 он

**5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл /Улсын хэмжээнд/ 2019-2023**




**Нялхасын эндэгдэл, Монгол Улс 2019-2023**




2023 оны жилийн эцсийн байдлаар 1000 амьд төрөлтөд ногдох тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшин 14.5 промиль байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 2.7 промилоор өссөн үзүүлэлттэй байна.

Нийт 10 тохиолдлын 3 нь осол гэмлийн шалтгаант нас баралт бөгөөд 7 тохиолдлыг нялхсын эндэгдэл эзэлж байна

**Тав хүртэлх насны хүүхдийн эндэгдэл, /Аймгийн хэмжээнд / 2019-2023**




**Тав хүртэлх насны хүүхдийн эндэгдэл, Аймаг 2023**



# ТАВ ХҮРТЭЛХ НАСНЫ ХҮҮХДИЙН ЭНДЭГДЭЛ /1000 амьд төрөлтөд / 2019-2023 он

Нийт нас барсан тохиолдлыг насаар нь авч үзэхэд 0-6 долоо хоногтой болон эрт нярайн 25 хувь, 7-28 долоо хоногтой хожуу нярай 33,3 хувь, 29-364 хоногтой нялхсын эндэгдэл 16,6 хувь, 1-5 хүртэлх хүүхдийн эндэгдэл 25 хувийг эзэлж байна.

**Эндэгдлийн насны ангилал (2019-2023)**




**Хүйс**




**Хүүхдийн эндэгдэл (Эрүүл мэндийн байгууллагаар) 2019-2023**



# ТАВ ХҮРТЭЛХ НАСНЫ ХҮҮХДИЙН ЭНДЭГДЭЛ /Сумдаар/ 2019-2023

| ЭМБ | Тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн тоо | | | | | Нялхсын эндэгдлийн тоо | | | | | Нярайн эрт үеийн эндэгдлийн тоо | | | | | Нярайн хожуу үеийн эндэгдэл | | | | | Нийт |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 2019 | 2020 | 2021 | 2022 | 2023 | 2019 | 2020 | 2021 | 2022 | 2023 | 2019 | 2020 | 2021 | 2022 | 2023 | 2019 | 2020 | 2021 | 2022 | 2023 | |
| Адаацаг | 2 | 1 | 2 | | | 1 | 1 | 1 | | | | 1 | | | | | | | | | 5 |
| Баянжаргалан | | | | | | | | | | | | | | | | | | | | | 0 |
| Говь-Угтаал | 1 | | | | | 1 | | | | | 1 | | | | | | | | | | 1 |
| Гурвансайхан | | | | 3 | | | | | 3 | | | | | 3 | | | | | | | 3 |
| Дэрэн | | | 1 | | 1 | | | 1 | | | | | | | | | | | | | 2 |
| Дэлгэрхангай | | 1 | | | | | 1 | | | | | 1 | | | | | | | | | 1 |
| Дэлгэрцогт | 1 | | | | | | | | | | | | | | | | | | | | 1 |
| Луус | | | | | | | | | | | | | | | | | | | | | 0 |
| Өндөршил | | | | | | | | | | | | | | | | | | | | | 0 |
| Өлзийт | | | | 1 | | | | | 1 | | | | | | | | | | | | 1 |
| Сайхан-Овоо | | 1 | 1 | | | | | 1 | | | | | | | | | | | | | 2 |
| Сайнцагаан | | | | | | | | | | | | | | | | | | | | | 0 |
| Хулд | | | | | | | | | | | | | | | | | | | | | 0 |
| Цагаандэлгэр | | | | | | | | | | | | | | | | | | | | | 0 |
| Эрдэнэдалай | 2 | | 1 | | 1 | 2 | | 1 | | | 1 | | | | | | | | | | 4 |
| Боржигонмандал | | | | | | | | | | | | | | | | | | | | | 0 |
| Өлзийтмандал | | | | 1 | | | | | 1 | | | | | | | | | | | | 1 |
| Нэгдсэн эмнэлэг | 3 | 6 | 8 | 3 | 8 | 3 | 5 | 8 | 3 | 3 | 3 | 3 | 4 | 2 | 2 | 1 | | 1 | 3 | 1 | 28 |
| **Нийт** | **9** | **9** | **13** | **8** | **10** | **7** | **7** | **12** | **8** | **8** | **5** | **5** | **4** | **5** | **5** | **1** | **0** | **1** | **3** | **1** | **49** |

# НЯЛХАС, НЯРАЙН ЭНДЭГДЭЛ
## /1000 амьд төрөлтөд / 2019-2023 он

### Нялхасын эндэгдэл /аймаг/ 2020-2023




### Эндсэн нярайн тээлтийн нас, Хувиар, Монгол Улс 2020-2023




### Эндсэн нярайн тээлтийн нас, Хувиар,Аймаг 2020-2024












# НЯРАЙН ЭНДЭГДЭЛ 2019-2023

**Эндсэн дутуу нярай эзлэх хувь (Дутуу төрөлтөд) Аймаг 2019-2023**




Нийт 125 дутуу төрснөөс 14 нярай эндсэн буюу 11,2 хувийг эзэлж байна. Иймд дутуу төрсөн нярайн эндэгдэл сүүлийн жилүүдэд тогтвортой буурахгүй байна.

**Эндсэн гүйцэд нярай эзлэх хувь (Гүйцэд төрөлтөд) 2019-2023**




**Нярайн эндэгдэлд эрт, хожуу үеийн эзлэх хувь, Монгол Улс (2019-2023 он)**




**Нярайн эрт, хожуу үеийн эндэгдэлд эзлэх хувь,Аймаг 2019-2023**



## Хүүхдийн эндэгдлийн шалтгаан / аймаг / (2019-2023)

Нийт эндэгдлийн шалтгааны 21,0 хувийг осол, гэмтлийн шалтгаан эзэлж байна.
Нийт эндэгдлийн шалтгааны 38,8 хувийг пренаталь үед үүссэн эмгэг эзэлж байна.




2023 онд тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн 4 буюу 40 хувийг нярайн ишемийн шалтгаант энцефалопати шалтгаант эндэгдэл эзэлж байна







2023 онд эндсэн 7 тохиолдлын 4 нь дутуу нярай бөгөөд нярайн ишемийн шалтгаант энцефалопатийн шалтгаант эндэгдэл байна. Гүйцэт нярайн 3 тохиолдол нь хахах болон төрөлтийн үеийн гэмтлийн шалтгаант эндэгдэл байгаа нь сэргийлж болох эндэгдэл гэж үзэж байна.

## Хүүхдийн эрүүл мэндийн үзүүлэлт
## (2019-2023)

- 0-5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл 2 тохиолдлоор өсөж эндэгдлийн түвшин 2,7 промилоор өссөн.
- Нялхсын эндэгдэл 1 тохиолдол буюу 1,7 промилоор буурсан.
- Нялхсын эндэгдэл дотроо нярайн хожуу эндэгдэл 3 тохиолдлоор өссөн
- Перинаталь эндэгдлийн тохиолдол 6 тохиолдол буюу 8,9 промилоор буурсан байна.

| Үзүүлэлт | 2019 | 2020 | 2021 | 2022 | 2023 | 2023 / 2022 |
|---|---|---|---|---|---|---|
| Тав хүртэлх насны хүүхдийн эндэгдэл | 9 | 9 | 13 | 8 | 10 | 2 тохиолдлоор өссөн |
| Тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшин | 9.5 | 10.0 | 15.2 | 11.8 | 14.5 | 2.7 промилоор өссөн |
| Нялхсын эндэгдэл | 7 | 7 | 12 | 8 | 7 | 1 тохиолдлоор буурсан |
| Нялхсын эндэгдлийн түвшин | 7.4 | 7.8 | 14.0 | 11.8 | 10.1 | 1.7 промилоор буурсан |
| Нярайн эндэгдэл | 5 | 6 | 7 | 6 | 7 | 1 тохиолдлоор өссөн |
| Нярайн эндэгдлийн түвшин | 5.3 | 6.7 | 8.2 | 8.9 | 10.1 | 1.2 промилоор өссөн |
| Нярайн эрт үеийн эндэгдэл | 5 | 5 | 4 | 5 | 3 | 2 тохиолдлоор буурсан |
| Нярайн эрт үеийн эндэгдлийн түвшин | 5.3 | 5.6 | 4.7 | 7.4 | 4.3 | 3.1 промилоор буурсан |
| Нярайн хожуу үеийн эндэгдэл | 0 | 1 | 3 | 1 | 4 | 3 тохиолдлоор өссөн |
| Нярайн хожуу үеийн эндэгдлийн түвшин | 0 | 1.1 | 3.5 | 1.5 | 5.7 | 4.2 промилоор өссөн |
| Перинаталь эндэгдэл | 8 | 5 | 8 | 9 | 3 | 6 тохиолдлоор буурсан |
| Перинаталь эндэгдлийн түвшин | 8.4 | 5.6 | 9.3 | 13.2 | 4.3 | 8.9 промилоор буурсан |

# 3.ДҮГНЭЛТ

1. Хүүхдийн эндэглийн түвшин 2023 онд өссөн бөгөөд үүнээс нялхсын эндэгдэл тохиолдлын хувьд буурсан боловч хүүхдийн осол гэмтлийн шалтгаант эндэгдэл 3 тохиолдол бүртгэгдсэн байна.
2. Нярайн эндэгдэл туушдаа буурахгүй байгаа нь жирэмсний хяналтын чанар муу,эмнэлгийн тусламж үйлчилгээний дутагдал байгааг харуулж байна.
3. Дутуу нярайн эндэгдлийн эзлэх хувь сүүлийн жилүүдэд өссөн үзүүлэлттэй байна.
4. Эндэгдлийн голлох шалтгаан нь перинаталь үеийн эмгэг эзэлж байгаа нь нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүдийн эрүүл мэндийг урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулж эрүүлжүүлэх, жирэмсэн үед перинаталь оношлогоог сайжруулах шаардлагатай байна.
5. Жирэмсний эрт үеийн хяналтын хувь буурсан.Жирэмсэн эхчүүд хугацаандаа хяналтанд орохгүй байгаа нь эмнэлгийн байгууллагаас иргэдэд жирэмсний хяналтын ач холбогдлын талаар сургалт сурталчилгаа хангалтгүй байна.
5. Охидын төрөлт буурч байгаа боловч өсвөр насны охидын дэрэлтийн эзлэх хувь өндөр хэвээр байна.

## 4. ЦААШИД АВЧ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ

1. **Тусламж үйлчилгээг сайжруулах чиглэлд**

1.1 Нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүдийг урьдчилан сэргийлжх үзлэг шинжилгээнд хамруулж эрүүлжүүлэлтийг сайжруулах
1.2 Эрүүл мэндийн хувьд эрсдэлтэй эмэгтэйчүүдэд гэр бүл төлөвлөлтийн аргад хамруулах
1.3 Жирэмсний хяналтын хамрагдалтыг нэмэгдүүлэж чанарыг сайжруулах
1.4 Төрөх үеийн болон төрсний дараах тусламж үйлчилгээг сайжруулах
1.5 Нярайн тусламж үйлчилгээг сайжруулах
1.6 Хүүхдийн цогц тусламж үйлчилгээг сайжруулах
1.7 Эхийн амрах байрны нөхцөлийг сайжруулж хамрагдпалтыг нэмэгдүүлэх

**2. Эмч мэргэжилтний мэдлэг ур чадварыг сайжруулах**

2.1 Сумдын эх баригч эмч нарыг жирэмсний нэрийн хяналтыг нэвтрүүлэх туршлага судлах сургалтанд хамруулах
2.2 Эх баригч нарыг ажлын байранд дадлагажуулах сургалтанд тасралтгүй сургах
2.3 Эмч мэргэжилтнүүдэд жирэмслэлт төрөлтийн үеийн хүндрэлийн удирдах арга зүйд сургах
2.4 Сумдын эмч нарт нярайн тусламж үзүүлэх чадавхыг нэмэгдүүлэх
2.5 ХӨЦМ-ийн сургалтыг зохион байгуулаж хэрэгжилтэнд тандалт хийх

**3. Эрүүл мэндийн боловсрол олгох**

3.1 Иргэдэд жирэмсний хяналт,гэр бүл төлөвлөлтийн талаар мэдээлэл сургалт сурталчилгааг тогтмол хийх
3.2 Өсвөр насны хүүхдүүдэд шилжилтийн насны онцлог,бэлгийн бойжилын талаар сургалт хийх
3.3 Нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүдийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх

зэрэг арга хэмжээнүүдийг төлөвлөн хэрэгжүүлэх шаардлагатай байна.

## 5. 2024 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХЭЭР ТӨЛӨВЛӨСӨН АРГА ХЭМЖЭЭ

Эх хүүхэд үзүүлэх эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг дээшлүүлэх, дээрх арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэх зорилгоор ЭМГ-ын даргын 2024 оны 01 дүгээр сарын 02 –ны өдрийн А/01 дугаар тушаалаар 2024 оныг “Эх,хүүхдийн тусламж үйлчилгээний чанарыг сайжруулах жил” болгон аймгийн хэмжээний хэрэгжүүлэх 8 зорилт,41 арга хэмжээ бүхий нэгдсэн төлөвлөгөө гарган ЭМГ-ын даргаар батлуулан хэрэгжүүлэн ажиллаж байна.

Төлөвлөгөөнд:

1. Хүний нөөцийн сургаж чадавхжуулах
2. Нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүдийн тусламж үйлчилгээг сайжруулах
3. Жирэмсний хяналтанд “Нэрийн хяналт”-ыг нэвтрүүлэх
4. Перенаталь оношлогоог сайжруулах
5. Эх нярайн тусламж үйлчилгээ үзүүлэх орчин нөхцөл,тоног төхөөрмжийг сайжруулах
6. Хүүхэд өсвөр үеийн тусламж үйлчилгээг сайжруулж ХӨЦМ-ийн хэрэгжилтийг хангаж ажиллах
7. Олон нийтийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх зэрэгт голлон анхаарч ажилласхаар төлөвлөсөн байна.

# АНХААРАЛ ТАВЬСАНД БАЯРЛАЛАА

